



БАЯНХОНГОР АЙМАГ
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/70

Хөхбүрд

Аймгийн Засаг даргын Тамгын газарт
газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, Авто замын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Засгийн газрын 2025 оны А/121 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 3.1.5, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Хуралдааны 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 03/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар зохион байгуулалтын 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан "Хатуу хучилттай зам"-ын зориулалттай, 1389778 м² газрыг аймгийн Засаг даргын Тамгын газарт 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлж холбогдох мэдээллийг хавсралтаар баталсугай.

2. Эзэмшил газрыг цахим системд бүртгэн цахим гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэн ажиллахыг Газрын даамал (Э.Түвшинжаргал)-д үүрэг хариуцуулсугай.


3. Тогтоосон чиглэлийн дагуу замыг тэмдэгжүүлэн, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, замын арчлалтыг тогтмол гүйцэтгэн хүн, мал амьтан, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, тоосжилтыг бууруулах арга хэмжээг зохион байгуулж байхыг аймгийн Засаг даргын Тамгын газарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орло: (Д.Гансүх)-д даалгасугай.

ДАРГА  Т.БЯМБАДОРЖ



642501079



Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн 11/10 дүгээр захирамжийн хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Газар эзэмшигч иргэдийн мэдээлэл							
	Хуулийн этгээдийн нэр	Регистрийн дугаар	Түр нэгж талбарын дугаар	Нэгж талбарын хаяг	Газрын хэмжээ /м²/	Газрын эрхийн төрөл	Газар ашиглалтын зориулалт	Газар эзэмшүүлэх, ашиглуулах хугацаа
1	Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газар	9007342	4446863	Уранхайрхан 2-р баг	1389778	Эзэмших	Хатуу хучилттай зам	15 жил